

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР  
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/**

2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 2 зорилгын 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2022 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 2 зорилтын 21 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтад авагдсан 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 40.95 %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- Зорилго 3.2. “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ” гэсэн зорилгын хэрэгжилт 39.5 хувь,
- Зорилго 5.1. “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хэрэгжилт 70.0 хувь,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх

шаардлагатай 5 /70%/, эрчимжүүлэх шаардлагатай 3 /50%/, хэрэгжилт хангалтгүй 12 арга хэмжээ /30%/, “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 /0/ арга хэмжээ тус тус байна. (Хүснэгт.1)

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт /2022 оны эхний хагас жилийн байдлаар/

Хүснэгт 1

Зорилго	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
		100	90	70	50	30	0	
Зорилго 3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	20			4	3	12	1	39.5%
Зорилго 5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	1			1				70.0%
Нийт дүн	21			5	3	12	1	40.95%

**2022 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй 12 арга хэмжээ байна. Үүнд:**

- 3.2.5 Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх
- 3.2.6 Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх
- 3.2.7 Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах
- 3.2.8 Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх
- 3.2.9 Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх
- 3.2.10 Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах
- 3.2.12 Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын

- тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах
8. 3.2.13 Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх
  9. 3.2.14 “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих
  10. 3.2.15 “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх
  11. 3.2.16 “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих
  12. 3.2.17 Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх

Эдгээр 12 арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувиар үнэлэгдлээ.

**2022 оны хагас жилийн байдлаар “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:**

1. (3.2.21- Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах арга хэмжээ)

#### **Дөрөв. Дүгнэлт**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 40.95 хувьтай үнэлэгдэв.
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 5 /70%/, эрчимжүүлэх шаардлагатай 3 /50%/, хэрэгжилт хангалтгүй 12 арга хэмжээ /30%/, “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 /0/ арга хэмжээ тус тус байна.

#### **Тав. Санал, зөвлөмж**

1. Цаашид салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах,
2. Нэгжүүд Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, арга хэмжээ нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, хүрэх үр дүнтэй болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, зорилго, зорилт, хүрэх түвшинтэй хэрхэн уялдаж байгааг биелэлт гаргахдаа хамт тайлагнаж байх,

3. Хэрэгжилт хангалтгүй “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар хариуцсан нэгжүүд онцгой анхаарч тусгайлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах.

Хянасан:


ХШҮДАГ-ын дарга



Ц.Одхүү

Танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн



Д.Батнайрамдал  
/2022.06.15/

Төлөвлөгөөний хэрэгжилтэнд ХШҮ хийсэн:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Батнайрамдал

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН  
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ  
/2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР/

№	Зорилт /бодлогын үндэслэл /	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө		Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн хувь
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Эх үүсвэр		
1	2	3	4	5	6	7	8	9
Зорилго 3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.								
3.2.1	ЗГҮАХ-3.2.3	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулах	Гүйцэтгэл 40.06 хувьтай байна.	Гүйцэтгэл 45 хувьд хүрсэн байна.	11,166.4	Улсын төсөв	Цахир мушгиа уул-50, Олон гол-50, Номгоны нуруу-50, Худгийн нуруу-50 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Ингэснээр 14,278.29 км <sup>2</sup> талбай буюу 0.91%, нийтдээ 41.97%-ийг судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 4 төслийн судалгааны үр дүнд алтны шороон илрэл Хуурай сайр (P2 зэргээр 224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр 1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр 80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимон металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн) зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй 20 талбайг ялгасан. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан 2020 оны 11-р сараас эхэлсэн бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой нөхцлөөс хамаарч Сүүжийн говь-50, Цайлангийн нуруу-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Их Өлзийт-50, Чулуун хороот-50, Түдэвтэй-50, Дэвийн хонгор уул-50, Модот толгой-50, Бүрхтэй уул-50, Асгат уул-50 төслүүдийн үр дүнгийн тайлан боловсруулах ажил удааширсантай холбоотойгоор нутаг дэвсгэрийг хамруулах зорилтот түвшинд хүрээгүй. 2022 оны жилийн эцэст эдгээр төслүүдийн үр дүнг хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 2.98% буюу 45%-ийг бүрэн бүрхэх боломж бүрдэнэ. 2022 онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1. Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан.	70%

							<p>2. Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХУСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулсан.</p> <p>3. Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50, нийт 6 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2022.01.20-ны өдөр УУХУ-ийн Дэд сайдаар батлуулсан.</p> <p>4. Төслүүдийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХУСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ны өдөр <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээр зарласан бөгөөд 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хураангуй жагсаалтад орсон оролцогчид хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. Хамгийн сайн оролцогчоор шалгарах хуулийн этгээдийг шалгаруулах ажиллагаа хийгдэж байна.</p>	
3.2.2	ЗГҮАХ-3.2.3	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах	Гүйцэтгэл 60 хувьтай байна.	Гүйцэтгэл 66 хувьд хүрсэн байна.	163.7	Улсын төсөв	<p>1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.</p> <p>2. Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХУСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.</p> <p>3. 2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг судалгаанд хамруулсан бөгөөд үр дүнгийн тайланг 2023 онд хүлээн авна.</p>	70%
3.2.3	ЗГҮАХ-3.2.3	Геохимийн 1:1000000-ны масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулах	Гүйцэтгэл 32 хувьтай байна.	Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна.	100.9	Улсын төсөв	<p>1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км<sup>2</sup> талбайд буюу 32.1%-д 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нийт нутаг дэвсгэрийг уг төслийн ажилд 100% хамруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км<sup>2</sup> буюу 67.9%-д хээрийн судалгаагаар хамруулж дууссан.</p> <p>2. 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнд боловсруулан үр дүнгийн тайлан хамгаалах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн.</p> <p>3. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХУСайдын шийдвэрээр баталгаажуулах ажил хийгдэж байна.</p>	70%

3.2.4	ЗГҮАХ-3.2.4	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	Гүйцэтгэл 10 хувьтай байна.	Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна.	500.0	Улсын төсөв	<p>1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.</p> <p>2. Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.04.14-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд 2022.05.11-ний өдөр тендерийн урилгыг хураангуй жагсаалтад орсон 3 оролцогчид хүргүүлж 2022.06.10-ний өдөр тендерийг нээхээр ажиллаж байна.</p>	50%
3.2.5	ЗГҮАХ-3.2.3	Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх	2 төсөл	6 төсөл	1,300.0	Улсын төсөв	<p>1. 2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геозкологи-2019, ДА геозкологи-2020, ХО геозкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1 нэртэй төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлан ажлыг эхлүүлсэн.</p> <p>2. Төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.</p> <p>3. 2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	30%
3.2.6	ЗГҮАХ-3.2.5	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлвийн үнзлгээ өгөх	1 төсөл	2 төсөл	1,000.0	Улсын төсөв	<p>1. Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын үр дүнг цар тахлын нөлөөнөөс шалтгаалан 2021 онд хүлээн авах боломжгүй болсон бөгөөд 2022 онд хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>2. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлан ажлыг эхлүүлсэн. Төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.</p> <p>3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.</p> <p>4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.</p>	30%

							5. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ны өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хураангуй жагсаалтад орсон 3 оролцогчид хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. Хамгийн сайн оролцогчоор шалгарах хуулийн этгээдийг шалгаруулах ажиллагаа хийгдэж байна.	
3.2.7	ЗГҮАХ-3.2.4	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	Гүйцэтгэл 5 хувьтай байна.	Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна.	1,000.0	Улсын төсөв	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна. 3. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.04.14-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд хураангуй жагсаалт үүсээгүй тул тендерийг 2022.05.04-ний өдөр дахин зарласан. Хураангуй жагсаалт үүсгэхэр ажиллаж байна.	30%
3.2.8	ЗГҮАХ-3.2.3	Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх	1 төсөл	3 төсөл	1,450.0	Улсын төсөв	1. 2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагений судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Геологийн орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар 3-р сард хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна. 3. Геологийн орчин-2022, БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна. 4. Төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд Мета-алт-500 төслийн тендэрт хураангуй жагсаалтад багтсан оролцогч нарт 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. Мета-алт-500 төслийн хамгийн сайн оролцогчоор шалгарах хуулийн этгээдийг шалгаруулах ажиллагаа хийгдэж байна.	30%



							5. Геологийн орчин-2022, БМШАМ-2022 хураангуй жагсаалт үүсээгүй тул тендерийг 2022.03.30-ны өдөр дахин зарласан. Хураангуй жагсаалтад багтсан оролцогч нарт 2022.05.11-ний өдөр тендерийн урилгыг хүргүүлж 2022.06.10-нд нээхээр ажиллаж байна.	
3.2.9	ЗГҮАХ-3.2.5	Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх	2 төсөл	4 төсөл	3,566.8	Улсын төсөв	1. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021 болон БӨМ-Алт-2019 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна. 2. Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 3. Төслийн гүйцэтгэчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна. 4. Төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд төслийн тендерт хураангуй жагсаалтад багтсан оролцогч нарт 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. ЭҮ-4-2022 төслийн хамгийн сайн оролцогчоор шалгарах хуулийн этгээдийг шалгаруулах ажиллагаа хийгдэж байна.	30%
3.2.10	МУТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.8	Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах	Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг тусгай хэрэгцээнд авсан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	530,100.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	Дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж барих гүйцэтгэчийг шалгаруулсан. Төслийг гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт 2022.02.18-ны өдрийн УУХҮСайдын 01/418 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, 2022.03.02-ны өдрийн дамжуулах хоолой барихад шаардагдах санхүүжилтийг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх тухай 94 дүгээр тогтоол батлагдсан. 2022.04.18-ны өдөр талууд хамтран ажиллах ерөнхий гэрээг УУХҮЯ, МГТБҮ ТӨХХК, ЭТТ ХК, Норинко компаниуд хооронд байгуулсан. Мөн дамжуулах хоолойн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг МГТБҮ ТӨХХК болон Норинко Интернейшнл компанитай, дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх гэрээг МГТБҮ ТӨХХК болон ЭТТ ХК-тай, нүүрс худалдах, худалдан авах гэрээг ЭТТ ХК болон Норинко Интернейшнл компанитай тус тус байгуулаад байна. МГТБҮ ТӨХХК болон Норинко Интернейшнл хооронд байгуулсан хоолойн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд инженер техникийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэнэ.	30%

3.2.11	МУТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.8	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх	Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн лицензтэй байгууламжийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензтэй байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 60 хувьд хүргэсэн байна.	288,456.9	Гадаадын зээл, тусламж	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.05.01-ний өдрийн байдлаар 50,0%-тай байна. Эдгээрт Бор хөөврийн говиос ус дамжуулах шугам хоолойн ажлууд болох өргөх станцын барилга-24,0%, 11 ширхэг худгийн барилга-35,0%, ус нөөцлөх савны барилга-70,0%, ЦДАШ-61,0%, үйлдвэрийн хашаан доторх авто зам-24,0%, зам талбайн ус зайлуулах хоолой-17,0%, зам талбайн ус хураах талбай-82,5%, замын доорх ус дамжуулах хоолой-89,0%, захиргааны барилга-31,0%, ажилчдын хоолны газрын барилга-74,0%, эмнэлгийн барилга-76,0%, лабораторийн барилга-78,0%, орц-53,0%, гарц-33,0%, засварын газрын барилга-27,0%, агуулахын барилга-33,0%, гал командын барилга-36,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй буюу ЕРС-1 багц ажлын нийт гүйцэтгэл 50,0%-тай явагдаж байна. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.12.30-нд хүлээн авсан. Тендерт босго үнээс давсан үнийн санал ирсэн тул яриа хэлэлцээ хийж байна. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын тендерт 1 компани санал ирүүлсэн, техникийн үнэлгээ хийгдэж байна, Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс техноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компанитай тус тус гэрээг байгуулаад байна.	50%
3.2.12	ЗГҮАХ-3.2.8	Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах	Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Хэрэгжилт 10	Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна /20 хувь/.	-	-	Засгийн газрын 2017 оны 92 дугаар, ТӨБЗГ-ын 2017 оны 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит компанийг байгуулсан. ЗГХЭГ-ын дарга болон УУХҮСайд нарын 2021 оны 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит "Эрчис Ойл" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ, "Эрдэнэс метан" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 47 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан УУХҮСайд 2021 оны 03 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн. Газрын тосны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани	30%

			хувьтай байна.				байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган боловсруулж байна.	
3.2.13	МУТЖҮЧ-4.2.1,4.2.1 1, ЗГҮАХ-3.2.1	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх	Гүйцэтгэл 10 хувьтай байна.	Гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	1,500.0	Улсын төсөв	2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. 2022 онд 211.0 сая төгрөгөөр далд уурхайн хэвтээ ам нээх, бэхэлгээ, агааржуулалт, гэрэлтүүлэг хийх, 250.0 сая төгрөгөөр хагас үйлдвэрлэлийн дээж бэлтгэх, 1039.0 сая төгрөгөөр хагас үйлдвэрлэлийн туршилт хийхээр төлөвлөсөн. Дээрх ажлууд хийгдсэнээр лабораторийн туршилт хийлгэх технологийн дээж авах боломжтой болно. Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021.08.31-ний өдрийн 0172 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн УУХҮСайдын 2021.08.31-ний өдрийн 01/2133 дугаар албан бичгээр Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны төсвийн төслийн ТЭЗҮ, зураг, төсвийн жагсаалтад Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд шаардлагатай туршилт, судалгааны ажлыг тусгуулахаар санал хүргүүлсэн. 2022 оны төсвийн төсөлд 1.0 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Манай яамнаас “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардагдах ТЭЗҮ, судалгаа” төсөл, арга хэмжээнд батлагдсан хөрөнгийг тус ордод нарийвчилсан хайгуулын ажил хийж, нөөцийг тодотгох арга хэмжээний зардалд шилжүүлэх тухай хүсэлтийг БХБ-ын яаманд хүргүүлсэн. БХБСайдын 2022.03.03-ний өдрийн 1/856 дугаар албан бичгээр Их Хурлын Байнгийн хорооны 2022 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын 3-т Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хариуцуулсан заалт болон холбогдох хуультай нийцэхгүй байх тул шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д (О.Хуланд) даалгасан. УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/801 дугаар албан бичгээр ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх саналаа яаралтай танилцуулахыг үүрэг болгосон. 2022 оны хагас жилийн байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн.	30%
3.2.14	МУТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.7	“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн “Уул уурхай-металлурги-	Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль	Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж,	128,663.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	Автозам: Зураг төслийн ажлыг Ихэр мөнх ХХК гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Төмөр зам: Зураг төслийн ажлыг Максималь ХХК гэрээ байгуулан ажиллаж гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан.	30%

		химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулсан /5 хувь/.	төмөр зам, ариутгах татуургын сүлжээ барих ажлыг гүйцэтгэнэ /100 хувь/.			Усан хангамж, ариутгал татуургын систем: Зураг төслийн ажлыг Чанарын түншлэл ХХК гэрээ байгуулан зураг төслийг 2 хувилбараар гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулах ажил хийгдэж байна. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ: Боловсруулах ажлыг Бодит чадал ХХК гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хугацаанд ажлыг 100% гүйцэтгэж ЭХЯамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгийг сонгох тендер шалгаруулалт эхэлсэн.	
3.2.15	МУТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.7	“Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан /1 хувь/.	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженерийн зураг төсөл боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гүйцэтгэлийг 10 хувьд хүргэсэн байна.	670,451.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ China ENFI Engineering компанитай хамтран боловсруулсан. УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. ЗБХБҮ-ийн зураг төслийн ажлыг ойрын хугацаанд эхлүүлхээр төлөвлөж байна	30%
3.2.16	МУХОХ-2.41, ЗГҮАХ-3.2.7	“Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан /1 хувь/.	Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэсэн байна /100 хувь/.	167,371.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл	Катодын зэсийн үйлдвэрийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажилд “Майнин шорт лонг терм” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Исэлдсэн хүдрийн 8А, 12-р овоолго болон уурхайгаас нийт 4 тн исэлдсэн хүдрийн дээжийг авч Технологийн туршилтын ажил хийгдэж байна. Туршилтын үр дүнд үндэслэн ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэнэ. УУХҮСайдын 2022.05.03-ны өдрийн А/91 дугаар тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Эрдэнэтийн овоо зэс молибдены ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ-д шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна.	30%

		технологийн катодын зэсийн үйлдвэр барих						
3.2.17	ЗГҮАХ-3.2.1	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх	Гүйцэтгэл 32 хувьтай байна.	Гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	292,181.8	Гадаадын зээл, тусламж	Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг компани" /СМЕС/ боловсруулж 2021.04.01-ний өдрийн ЭБМЗ-ийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. ЗГ-ын 2021.04.28-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 113 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолд Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг ТЭЗҮ-ийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг УУХҮСайд болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-д даалгасан. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс "Чайна металлуржикал инженеринг" компанитай байгуулсан гэрээний дагуу 2 дугаар шатны ажил болох нүүрс баяжуулах үйлдвэрийн FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 8 дугаар сард дуусган хүлээж авсан. 2021.08.13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажилд 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд тус тендер 2 удаа амжилтгүй болж улмаар 2022.02.17-ны өдөр дахин тендерийг зарлаж, 2022.03.02-ны өдөр нээн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Төслийн гүйцэтгэгчээр шалгарсан Норинко Интернэшнл ХХК-тай 2022.04.14-ний өдөр гэрээ байгуулан талбайн инженер геодизийн судалгаа, түгээмэл тархацтай ордын судалгааны ажлуудыг эхлүүлээд байна.	30%
3.2.19	ЗГҮАХ-3.2.9	Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх	Ажлын хэсэг байгуулж, төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.	Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, байгалийн шавхагдах баялгийг	-	-	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсонтой холбогдуулан УУХҮСайдын "Зөвшөөрөл олгох тухай" 2022.05.24-ний өдрийн 01/1498, 01/1499 дугаар албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлээд байна.	70%

				эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үедээ тэгш, шударга хуваарилах боломжтой болно.				
3.2.20	ЗГҮАХ-3.2.2	Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 10 хувьтай байна.	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	27,650.0	Гадаадын зээл, тусламж	2021 оны эцэс, 2022 оны эхээр Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгал орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. Уурхайн налуу амыг бүрэн нэвтэрсэн ба 2022 оны эцэст нэвтрэлтийн хэмжээ 300 м - 450 м-т хүрч үндсэн малталтууд болон бэлтгэл малталтууд хийгдсэн. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. 2022 оны хагас жилийн байдлаар Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 30 хувьд хүрсэн.	50%
					11,850.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл		
3.2.21	ЗГҮАХ-3.2.7	Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах	Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженер-геологийн судалгаа хийгдсэн. Үйлдвэрийн барилга баригдсан. Тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн. Гүйцэтгэл	Гангийн үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийн татан авалт 88 хувьтай байна.	9,000.0	Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл	МДМУ ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил ковид-19 цар тахлын улмаас 2020 оноос 2022 оны 05 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн санхүүжилт толгой компани /"Монзол групп" ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдэгдсэн. Цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум төгрөгийн урьдчилгааг төхөөрөмж нийлүүлэгч компанид төлсөн боловч төлөвлөгөөний дагуу БНХАУ /"Qianxi ADI Mechanical Casting" Co.Ltd компани/-д очиж газар дээр нь тоног төхөөрөмжийн сонголт хийн оруулж ирэх, мөн мэргэжилтэн оруулж ирэх асуудал хилийн хөл хорионы улмаас шийдэгдэхгүй байна. 2020 оноос хойш ковид-19 цар тахлын улмаас төслийн ажил зогссон.	0

			16.4 хувьтай байна.					
<b>Бүлэг 5. Ногоон хөгжлийн бодлого</b>								
<b>Зорилго 5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</b>								
5.1.1	МУТЖҮЧ-3.6.3, 6.2.1, 6.2.4, ЗГҮАХ-5.1.8	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	1973.9 га талбайд техникийн. 634.8 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	40,000.0	Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн 2021 онд 2069,7 га-д техникийн нөхөн сэргээлт, 623.7 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу 2022 оны уулын ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2-р сард ирүүлдэг. 2022 оны хагас жилийн мэдээлэл гаргах боломжгүй байна.	70%
<b>ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН</b>								<b>40.95%</b>

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ